

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.060.25

| | |
|--|------------------------|
| Усны чанар Арьс, шир, үслэг боловсруулах үйлдвэрээс урьдчилан цэвэрлэх байгууламжид нийлүүлэх технологийн хаягдал ус. Техникийн шаардлага Water quality The raw waste water from the leather processing industry before the primary effluent threatment plant. Technical requirements | MNS 5582 : 2006 |
|--|------------------------|

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2006 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлав.

2006 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

Энэхүү стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

1. Зорилго

Энэ стандартын зорилго нь арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрүүдийн технологийн үйл ажиллагааны явцад ялгарч гардаг хаягдал усны найрлагад тавигдах ерөнхий шаардлагыг тогтооход оршино.

2. Хамрах хүрээ

Энэхүү стандартыг арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрүүдийн технологийн үйл ажиллагааны явцад ялгарч гардаг хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэх зорилгоор нийлүүлэх, найрлагыг хянахад мөрдөнө.

3. Норматив ишлэл

Энэ стандартад олон улсын болон үндэсний дараах стандарт, норм ба дүрэм, норматив баримт бичгүүдээс ишлэл хийсэн бөгөөд тэдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн албан ёсны эх материалыг баримтална. Үүнд:

1. MNS 5480 : 2005 Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага.
2. MNS 4943 : 2000 Хаягдал бохир ус. Техникийн шаардлага
3. ISO 11923:1997 Усны чанар - Шилэн шүүлтүүрээр умбуур бодисыг тодорхойлох арга.
4. ISO 5667-10:1992. Усны чанар - Дээж авах. 10-р хэсэг. Хаягдал уснаас дээж авах арга зүйн заавар.
5. ISO 5815:1989 Усны чанар - Биологийн хэрэгцээт хүчилтөрөгчийг тодорхойлох /5 өдрийн дараа/. (BOD 5) – Цийдмэгжүүлэх арга зүй.
6. ISO 6060:1989 Усны чанар - Химийн хэрэгцээт хүчилтөрөгчийг тодорхойлох.
7. ISO 5815:1989 Усны чанар – 3 валенттай хром тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга
8. ISO 10530:1994 Усны чанар - PH-тодорхойлох
9. Олон улсын байгаль орчны хорооноос гаргасан шаардлага. Герман улсын Фрайчхафен хот 1995 он.

4. Нэр, томъёо

4.1. Технологийн хаягдал ус: Арьс шир, үслэг боловсруулах технологийн үйл ажиллагааны явцад ялгарч гардаг хаягдал ус

4.2. Урьдчилан цэвэрлэх байгууламж: Арьс шир, үслэг боловсруулах технологийн үйл ажиллагааны явцад ялгарч гардаг хаягдал усыг хими, механикийн аргаар цэвэрлэж, дараагийн шатны цэвэрлэх байгууламж руу нийлүүлэх зориулалтын барилга байгууламж, тоног төхөөрөмж, технологи, ажиллах хүчний нэгдсэн цогцолбор

5. Ангилал

5.1. Боловсруулалтын төрлөөр нь:

- Арьс шир боловсруулах үйлдвэрийн технологийн хаягдал ус
- Үслэг арьс боловсруулах үйлдвэрийн технологийн хаягдал ус

5.2. Технологийн дамжлагын төрлөөр нь:

- дэвтээлгийн
- зөөлрүүлэг-шохойдлогын
- идээлгийн
- идээлгийн дараах дамжлагын
- гүйцэд боловсруулалтын

6. Шаардлага

6.1. Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрүүдийн технологийн үйл ажиллагааны явцад ялгарч гардаг голлох бохирдуулагч бодисын хэмжээ нь 1-р хүснэгтэд заасан хэмжээнээс хэтрэхгүй байна.

Арьс шир, үслэг боловсруулах хэвшмэл технологийн явцад ялгарч гардаг голлох бохирдуулагч бодисын дээд хэмжээ

А. Үхрийн давсалсан шир боловсруулах

1-р хүснэгт

| 1 тонн түүхий эдэд | Ус м ³ /тонн | XXX кг/тонн | БХХ ₅ кг/тонн | Умбуур бодис кг/тонн | Cr ₃ кг/тонн | S кг/тонн | Нийт N ₂ кг/тонн | Хлорид кг/тонн | SO ₄ кг/тонн |
|---|----------------------------|----------------|-----------------------------|----------------------------|----------------------------|--------------|--------------------------------|-------------------|----------------------------|
| Дэвтээлэг, шохойдлогын | 25 | 160 | 60 | 120 | - | 9 | 14 | 150 | 20 |
| Тос авалт-идээлгийн | 3 | 20 | 7 | 10 | 5 | - | 1 | 60 | 50 |
| Идээлгийн дараах | 8 | 40 | 15 | 20 | 2 | - | 2 | 10 | 40 |
| Гүйцэтгэх | 1 | 10 | 4 | 5 | - | - | - | - | - |
| Нийт | 37 | 230 | 86 | 155 | 7 | 9 | 17 | 220 | 110 |
| Үхрийн шир, ямааны арьсыг жингээр нь дүйцүүлж тооцно. | | | | | | | | | |

Б. Хонины давсалсан нойтон арьс боловсруулах

| 1ш арьсанд | Ус, л | XXX, грамм | БХХ ₅ , грамм | Умбуур бодис, грамм | Cr ₃ , грамм | S, грамм | Нийт N ₂ , грамм | Хлорид, грамм | SO ₄ грамм |
|------------------------|------------|---------------|-----------------------------|---------------------------|----------------------------|-------------|--------------------------------|------------------|--------------------------|
| Дэвтээлэг, шохойдлогын | 150 | 600 | 260 | 300 | - | 20 | 30 | 300 | 15 |
| Тос авалт-идээлгийн | 70 | 300 | 100 | 30 | 12 | - | 10 | 200 | 70 |
| Идээлгийн дараах | 35 | 100 | 35 | 20 | 3 | - | 4 | 40 | 40 |
| Гүйцэтгэх | 10 | 5 | 2 | 2 | - | - | - | - | - |
| Нийт | 265 | 1005 | 397 | 352 | 15 | 20 | 44 | 540 | 125 |

Тайлбар:

XXX - Химийн хэрэгцээт хүчилтөрөгч

БХХ₅ - Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч /5 өдрийн дараа/Cr₃₊ - гурван цэнэгт хром

S - Хүхэр

SO₄ - Сульфат

6.2. Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрүүдийн технологийн үйл ажиллагааны явцад ялгарч гардаг хаягдал ус /цаашид технологийн хаягдал ус гэх/-ыг урьдчилан цэвэрлэх байгууламжид цэвэршүүлэх зорилгоор нийлүүлнэ.

6.3. Технологийн хаягдал усанд агуулагдах голлох бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь энэхүү стандартын 2-р хүснэгтэд үзүүлсэн шаардлагыг хангасан байна.

6.4. Технологийн хаягдал усыг шингэрүүлж эзэлхүүнийг нь нэмэгдүүлэхийг хориглоно.

6.5. Технологийн хаягдал усыг цэвэрлэхгүйгээр ус, хөрс, ариутгах татуургад хаяхыг хориглоно.

6.6. Гадаргын ус, хөрсөнд хаяж болох хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь MNS 4943 : 2000-д заасан шаардлагад нийцсэн байна.

Арьс, шир, үслэг боловсруулах үйлдвэрийн технологийн хаягдал усанд агуулагдах голлох бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

2-р хүснэгт.

| № | Үзүүлэлт | Зөвшөөрөгдөх дээд хэмжээ | Хэмжих нэгж |
|----------|---|---------------------------------|--------------------|
| 1 | Умбуур бодис | 5500 | мг/л |
| 2 | Химийн хэрэгцээт хүчилтөрөгч | 6200 | мг/л |
| 3 | Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч /БХХ ₅ / | 6000 | мг/л |
| 4 | Хром /3 цэнэгт/ | 100 | мг/л |
| 5 | Сульфат | 150 | мг/л |
| 6 | Хлорид | 5400 | мг/л |
| 7 | Усны орчин рН | 9,0 | - |

ТӨГСӨВ.